



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 28 өдөр

Дугаар А/107

Хэрлэн сум

Газар ашиглалтын зориулалтад  
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалт, "Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.4 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэн Уртнасангийн Одхүү (СЭ75031516) ирүүлсэн хүсэлтийн дагуу тус иргэний эзэмшлийн Хэрлэн сумын 1 дүгээр баг (Хэрлэн) Тэмүүжингийн гудамжид байрлах 3211 м<sup>2</sup> бүхий үйлчилгээний зориулалттай газрыг үйлчилгээтэй орон сууцны зориулалттай болгон зориулалтыг өөрчлөн 40 жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Иргэн У.Одхүүгийн эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, Барилга, хот байгуулалтын газар (Д.Баярхүү)-т үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн У.Одхүүд даалгасугай.

5.Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны А/145 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ